

МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ СУНГАХ МЭРГЭЖИЛТНИЙ БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 200 дугаар тушаалаар батлагдсан "Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох дүрэм"-ийн 4.5-д заасны дагуу МЭРГЭШСЭН АРХИТЕКТОР, ИНЖЕНЕР, ТӨСӨВЧИН зэргийг сунгах, ЗӨВЛӨХ АРХИТЕКТОР, ИНЖЕНЕР, ТЭРГҮҮЛЭХ ТӨСӨВЧИН зэргийг горилох, сунгах мэргэжилтнүүд дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:

1. Шалгалтад орох хүсэлт; ХҮСЭЛТИЙН МАЯГТ ТАТАХ
2. Иргэний үнэмлэхийн хуулбар, Нийгмийн даатгалын лавлагаа /Горилох бол сүүлийн 5 жилээр, сунгах бол сүүлийн 3 жилээр/
3. Цээж зураг 2 хувь /3см X 4см хэмжээтэй/
4. Нийгмийн даатгалын лавлагаа
5. Бүтээлийн тайлан. /Бүтээлийн тайлангаа аж ахуйн нэгж байгууллагын дарга захирал болон өөрийн мэргэжлийн чиглэлээр зөвлөх, тэргүүлэх зэрэгтэй 2-оос доошгүй мэргэжилтнээр баталгаажуулна. БҮТЭЭЛИЙН ТАЙЛАН МАЯГТ ТАТАХ
6. Мэргэжлийн дипломын хуулбар. Гадаадад мэргэжлийн боловсрол эзэмшсэн бол баталтгаат орчуулгыг хавсаргана. /2012 оноос хойш төгссөн бол E-Mongolia аппликэйшнээс лавлагаа авч хавсаргаж болно. 2012 оноос өмнө төгссөн бол нотариатаар баталгаажуулсан хуулбар байна.
7. Мэргэшсэн болон зөвлөх зэргийн гэрчилгээний хуулбар
8. Мэргэжил дээшлүүлсэн сургалтын гэрчилгээнүүдийн хуулбар / Багц цаг тооцсон сургалтын гэрчилгээ байна/
9. Мэргэжил дээшлүүлсэн тайлан. /Тайланг заавал суралцах багц цаг хангасан гэрчилгээ олгосон байгууллагаар баталгаажуулсан байна./ МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛСЭН ТАЙЛАН МАЯГТ ТАТАХ
10. Мэргэшсэн болон Зөвлөх зэрэг СУНГАХ мэргэжилтнүүд БИЕ ДААЛТЫН Багц цагийн тодорхойлолт баталгаа тамгатай байх /Мэргэжил дээшлүүлсэн тайлангийн маягтад байгаа/